

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Боловсрол шинжлэх ухааны газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БӨА-2025/186/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)  
Өлгий хот  
2024 он

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга  
бөгөөд тэргүүлэх аудитор: Ж.Айгүл

Утас: 70422954 Цахим хаяг: Aigulj@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Женисбек

Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn

Ахлах аудитор: М.Айнур

Утас: 94159291 Цахим хаяг: ainurm@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## **АГУУЛГА**

---

1. Хараат бус аудиторын дүгнэлт .....
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
  - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....
  - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....
  - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....
  - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт .....
4. Аудитын тайлан .....

  - 4.1 Ерөнхий зүйл .....
  - 4.2 Материаллаг байдал .....
  - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
  - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....
  - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....
  - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....

5. Аудитын илрүүлэлт .....
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл .....

### **Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,  
Утас/Факс: (976) 7042-2954  
E-mail: bayanulgii@audit.gov.mn

АЙМГИЙН БОЛОВСРОЛ ШИНЖЛЭХ  
УХААНЫ ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Б.АЙДЫН ТАНАА

2025.02.25 № 237  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Аймгийн Боловсрол шинжлэх ухааны газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Боловсрол шинжлэх ухааны газар нь 2024 онд 11,123.5 сая төгрөгийн батлагдсан төсвөөр ажиллаж, гүйцэтгэлээр 10,882.2 сая төгрөг зарцуулж, 97.8 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.

### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь

832502000206

харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

#### **Бусад асуудал**

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.АЙГҮЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/ төгрөгөөр /

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>63,244,120.23</u></b>	<b><u>344,714,154.72</u></b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	100,000.00	100,000.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	100,000.00	100,000.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>63,144,120.23</b>	<b>344,614,154.72</b>
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>63,144,120.23</b>	<b>344,614,154.72</b>
35410	Бичиг хэргийн материал	12,431,215.00	737,500.00
35420	Аж ахуйн материал	3,915,500.00	4,505,500.00
35470	Бусад хангамжийн материал	46,797,405.23	339,371,154.72
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>573,996,579.64</b>	<b>670,050,776.54</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>573,996,579.64</b>	<b>670,050,776.54</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>68,388,579.64</b>	<b>163,736,943.19</b>
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	120,687,936.80	221,618,707.80
39206	Хуримтлагдсан элэгдэл	-62,540,591.45	-90,842,624.77
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	41,980,211.00	68,428,260.36
39208	Хуримтлагдсан элэгдэл	-31,738,976.71	-35,467,400.20
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>505,608,000.00</b>	<b>506,313,833.35</b>
39303	Бусад биет бус хөрөнгө	505,608,000.00	506,378,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	0.00	-64,166.65
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>637,240,699.87</u></b>	<b><u>1,014,764,931.26</u></b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>637,240,699.87</u></b>	<b><u>1,014,764,931.26</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>637,240,699.87</b>	<b>1,014,764,931.26</b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	253,829,745.73	253,829,745.73
51101	Өмч: - төрийн	253,829,745.73	253,829,745.73
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>379,376,154.14</b>	<b>756,900,385.53</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	357,351,448.78	379,376,154.14
51220	Тайлант үеийн үр дүн	22,024,705.36	377,524,231.39
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	4,034,800.00	4,034,800.00
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>637,240,699.87</u></b>	<b><u>1,014,764,931.26</u></b>

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

**/ төгрөгөөр /**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>4,870,418,939.80</b>	<b>14,706,525,788.06</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>222,322,501.80</b>	<b>3,308,925,296.06</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>222,322,501.80</b>	<b>3,308,925,296.06</b>
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	17,424,000.00	121,949,684.94
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	204,898,501.80	3,186,975,611.12
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>4,648,096,438.00</b>	<b>11,397,600,492.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>4,556,131,500.00</b>	<b>11,123,546,200.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	4,556,131,500.00	11,123,546,200.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>91,964,938.00</b>	<b>274,054,292.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	750,000.00	0.00
131103	ЗГНХ,ЗДНХхөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	50,000,000.00	187,491,260.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	40,707,068.00	84,231,032.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	507,870.00	2,332,000.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>4,825,154,234.44</b>	<b>14,329,001,556.67</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>4,825,154,234.44</b>	<b>14,329,001,556.67</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>874,047,613.02</b>	<b>4,214,112,331.95</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>519,191,571.41</b>	<b>920,332,448.00</b>
210101	Үндсэн цалин	303,658,150.57	487,424,893.00
210102	Нэмэгдэл	128,446,963.00	298,332,575.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	52,559,994.84	62,790,000.00
210104	Урамшуулал	34,526,463.00	71,784,980.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>65,380,445.59</b>	<b>112,605,912.28</b>
210201	Тэтгэврийн даатгал	44,616,410.31	77,360,925.31
210202	Тэтгэмжийн даатгал	5,191,005.80	9,203,124.48
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,152,804.66	4,601,562.58
210204	Ажилгүйдлийн даатгал	1,038,201.14	4,288,059.27
210205	Эрүүл мэндийн даатгал	10,382,023.68	17,152,240.64
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>30,447,015.68</b>	<b>32,505,500.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	2,735,512.00	3,307,807.51
210302	Түлш, халаалт	24,636,497.68	26,077,692.49
210303	Цэвэр, бохир ус	3,075,006.00	3,120,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>191,759,728.51</b>	<b>2,918,961,609.03</b>
210401	Бичиг хэрэг	4,281,000.00	9,628,600.00
210402	Тээвэр, шатахуун	1,682,800.00	7,181,432.00

Боловсрол шинжлэх ухааны газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	461,619.90	1,093,100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	191,400.00	343,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,527,738.00	306,300.00
210408	Бараа материал акталсны зардал	1,753,520.00	0.00
210409	Бараа материал шилжүүлсний зардал	181,861,650.61	2,900,408,577.03
210410	Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/		
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>0.00</b>	<b>723,600.00</b>
210502	Хоол, хүнс	0.00	723,600.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>53,300.00</b>	<b>52,300.00</b>
210604	Урсгал засвар	53,300.00	52,300.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>2,000,000.00</b>	<b>76,374,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	2,000,000.00	76,374,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>397,500.00</b>	<b>527,175.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	397,500.00	527,175.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>64,818,051.83</b>	<b>152,029,787.64</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,554,000.00	6,307,499.60
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	44,105,926.00	118,026,800.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	16,158,125.83	27,695,488.04
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>3,951,106,621.42</b>	<b>10,114,889,224.72</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>3,786,034,559.00</b>	<b>9,873,576,172.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1,887,646,537.00	1,962,156,772.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	1,853,238,022.00	7,911,419,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	45,150,000.00	0.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>165,072,062.42</b>	<b>241,313,052.72</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	165,072,062.42	241,290,184.89
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		22,867.83
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>45,264,705.36</b>	<b>377,524,231.39</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>23,240,000.00</b>	<b>0.00</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	23,240,000.00	
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>-23,240,000.00</b>	<b>0.00</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>22,024,705.36</b>	<b>377,524,231.39</b>

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

**/ төгрөгөөр /**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>4,648,096,438.00</b>	<b>11,397,600,492.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>4,648,096,438.00</b>	<b>11,397,600,492.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	4,556,131,500.00	11,123,546,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	4,556,131,500.00	11,123,546,200.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	91,964,938.00	274,054,292.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	750,000.00	0.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	50,000,000.00	187,491,260.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	40,707,068.00	84,231,032.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	507,870.00	2,332,000.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>4,628,186,438.00</b>	<b>11,395,800,492.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>4,628,186,438.00</b>	<b>11,395,800,492.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>677,079,816.58</b>	<b>1,280,911,267.28</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	519,291,571.41	921,626,409.18
210101	Үндсэн цалин	304,291,056.26	494,312,728.00
210102	Нэмэгдэл	128,083,217.07	293,642,493.18
210103	Унаа хоолны хөнгөлөлт	52,539,994.84	62,220,686.00
210104	Урамшуулал	34,377,303.24	71,450,502.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	65,380,445.59	111,311,951.10
210201	Тэтгэврийн даатгал	44,616,410.31	81,004,051.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,191,005.80	7,654,060.85
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,152,804.66	3,827,380.70
210204	Ажилгүйдлийн даатгал	1,038,201.14	3,765,472.55
210205	Эрүүл мэндийн даатгал	10,382,023.68	15,060,986.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	30,447,015.68	32,505,500.00
210301	Гэрэл, цахилгаан	2,735,512.00	3,307,807.51
210302	Түлш, халаалт	24,636,497.68	26,077,692.49
210303	Цэвэр, бохир ус	3,075,006.00	3,120,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	6,290,207.90	14,494,032.00
210401	Бичиг хэрэг	1,686,650.00	4,169,600.00
210402	Тээвэр, шатахуун	1,682,800.00	7,181,432.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	461,619.90	1,093,100.00
210404	Ном, хэвлэл	200,000.00	0.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	191,400.00	343,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,067,738.00	1,706,300.00

Боловсрол шинжлэх ухааны газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	53,300.00	52,300.00
210604	Урсгал засвар	53,300.00	52,300.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	2,000,000.00	76,374,000.00
210702	Дотоод албан томилолт	2,000,000.00	76,374,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	397,500.00	527,175.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	397,500.00	527,175.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	53,219,776.00	124,019,900.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,554,000.00	4,467,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	48,665,776.00	119,552,400.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>3,951,106,621.42</b>	<b>10,114,889,224.72</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	3,786,034,559.00	9,873,576,172.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1,887,646,537.00	1,962,156,772.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	1,853,238,022.00	7,911,419,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	45,150,000.00	0.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	165,072,062.42	241,313,052.72
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	165,072,062.42	241,313,052.72
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>19,910,000.00</u></b>	<b><u>1,800,000.00</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b><u>19,910,000.00</u></b>	<b><u>1,800,000.00</u></b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b><u>19,910,000.00</u></b>	<b><u>1,800,000.00</u></b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	19,910,000.00	1,800,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	19,910,000.00	1,800,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>-19,910,000.00</u></b>	<b><u>-1,800,000.00</u></b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	0.00	0.00
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

**/ төгрөгөөр /**

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
<b>2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	253,829,745.73	14,402,900.00	346,983,348.78	615,215,994.51
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	10,368,100.00	10,368,100.00
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>253,829,745.73</b>	<b>14,402,900.00</b>	<b>357,351,448.78</b>	625,584,094.51
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	(10,368,100.00)	0.00	(10,368,100.00)
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00	0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	22,024,705.36	22,024,705.36
<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>253,829,745.73</b>	<b>4,034,800.00</b>	<b>379,376,154.14</b>	637,240,699.87
<b>2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>253,829,745.73</b>	<b>4,034,800.00</b>	<b>379,376,154.14</b>	637,240,699.87
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00		0.00
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>253,829,745.73</b>	<b>4,034,800.00</b>	<b>379,376,154.14</b>	637,240,699.87
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00		0.00	0.00
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				0.00
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	377,524,231.39	377,524,231.39
<b>2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>253,829,745.73</b>	<b>4,034,800.00</b>	<b>756,900,385.53</b>	<b>1,014,764,931.26</b>

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Үзүүлэлт	Тайлант оны	
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>11,123,546,200.00</b>	<b>10,882,256,015.11</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>11,123,546,200.00</b>	<b>10,882,256,015.11</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,010,942,000.00</b>	<b>1,008,679,843.11</b>
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>837,446,900.00</b>	<b>837,445,726.00</b>
Үндсэн цалин	539,673,600.00	494,312,728.00
Нэмэгдэл	204,280,300.00	209,461,810.00
Унаа хоолны хөнгөлөлт	32,761,500.00	62,220,686.00
Урамшуулал	60,731,500.00	71,450,502.00
Гэрээт ажлын хөлс		
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>104,680,900.00</b>	<b>102,420,742.11</b>
Тэтгэврийн даатгал	75,596,200.00	74,808,290.91
Тэтгэмжийн даатгал	7,271,200.00	6,947,622.98
ҮОМШӨ-ний даатгал	3,635,600.00	3,474,161.57
Ажилгүйдлийн даатгал	3,635,600.00	3,438,313.39
Эрүүл мэндийн даатгал	14,542,300.00	13,752,353.26
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>32,505,500.00</b>	<b>32,505,500.00</b>
Гэрэл, цахилгаан	3,333,600.00	3,307,807.51
Түлш, халаалт	26,050,200.00	26,077,692.49
Цэвэр, бохир ус	3,121,700.00	3,120,000.00
Байрны түрээс		
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>14,217,000.00</b>	<b>14,217,000.00</b>
Бичиг хэрэг	877,200.00	4,169,600.00
Тээвэр, шатахуун	10,961,700.00	6,904,400.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	231,900.00	1,093,100.00
Ном, хэвлэл	89,200.00	0.00
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	872,400.00	343,600.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,184,600.00	1,706,300.00
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>52,300.00</b>	<b>52,300.00</b>
Урсгал засвар	52,300.00	52,300.00
<b>Томилолт, зочны зардал</b>	<b>3,000,000.00</b>	<b>3,000,000.00</b>
Дотоод албан томилолт	3,000,000.00	3,000,000.00
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>528,000.00</b>	<b>527,175.00</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	528,000.00	527,175.00
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>18,511,400.00</b>	<b>18,511,400.00</b>
Бараа үйлчилгээний бусад зардал	4,467,500.00	4,467,500.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	14,043,900.00	14,043,900.00
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>10,112,604,200.00</b>	<b>9,873,576,172.00</b>

Боловсрол шинжлэх ухааны газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>10,112,604,200.00</b>	<b>9,873,576,172.00</b>
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	2,147,191,600.00	1,962,156,772.00
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	7,965,097,200.00	7,911,419,400.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	315,400.00	0.00
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>11,123,546,200.00</b>	<b>10,882,256,015.11</b>
<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>11,123,546,200.00</b>	<b>10,882,256,015.11</b>
Улсын төсвөөс санхүүжих	11,123,546,200.00	10,882,256,015.11
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1.00</b>	<b>1.00</b>
Төсвийн байгууллага	1.00	1.00
<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>32.00</b>	<b>32.00</b>
Удирдах ажилтан	1.00	1.00
Гүйцэтгэх ажилтан	25.00	25.00
Үйлчлэх ажилтан	6.00	6.00

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>91964938.00</b>	<b>274054292.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>91964938.00</b>	<b>274054292.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>44543576.00</b>	<b>274031424.17</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>0.00</b>	<b>84180683.18</b>
210102	Нэмэгдэл		84,180,683.18
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>0.00</b>	<b>8891208.99</b>
210201	Тэтгэврийн даатгал	-	6,195,760.09
210202	Тэтгэмжийн даатгал	-	706,437.87
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	353,219.13
210204	Ажилгүйдлийн даатгал	-	327,159.16
210205	Эрүүл мэндийн даатгал	-	1,308,632.74
210402	Тээвэр, шатахуун	-	277,032.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>0.00</b>	<b>1800000.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	1,800,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>0.00</b>	<b>73374000.00</b>
210701	Гадаад албан томилолт		
210702	Дотоод албан томилолт	-	73,374,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>44543576.00</b>	<b>105508500.00</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	<b>44,543,576.00</b>	<b>105,508,500.00</b>
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>47,421,362.00</b>	<b>22,867.83</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	44950000.00	
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>2,471,362.00</b>	<b>22,867.83</b>
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	2,471,362.00	22,867.83
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>91964938.00</b>	<b>274054292.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>91964938.00</b>	<b>274054292.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	750,000.00	
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	50,000,000.00	187,491,260.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	40,707,068.00	84,231,032.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	507,870.00	2,332,000.00
131106	Төсвийн урамшуулал		
131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого		
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

**3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

**3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

**Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар**

Аймгийн Боловсрол шинжлэх ухааны газрын зорилго “Хөгжлийн чиг хандлага, нийгэм, соёлын үнэт зүйл, хэрэгцээнд нийцүүлэн боловсролын тэгш хүртээмжтэй, чанартай үйлчилгээг хэрэгжүүлэх, таатай орчин бүрдүүлэх замаар бие даан сурах, ажиллах, амьдрах чадвартай, эрүүл чийрэг, эрдэм боловсролтой, эх оронч, хөрвөх чадвартай, бүтээлч иргэнийг төлөвшүүлж, боловсролын чанарт ахиц гаргахад оршино”.

Энэхүү зорилгыг хэрэгжүүлэх хүрээнд дараах зорилтыг хэрэгжүүлэн ажилласан байна.Үүнд:

- Хүний эрх, эрх чөлөө, нэр төр, ардчиллын үнэт зүйлс, үндэсний түүх, хэл, соёл, өв уламжлал, зан заншлыг хүндэтгэн хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, боловсролыг хувь хүний хөгжил, гэр бүлийн амьдралын баталгаа болгоно.
- Суралцагчдад ээлтэй, чанартай үйлчилгээ үзүүлэх сургалтын орчныг бүрдүүлж, хүртээмжийг нэмэгдүүлэх, боловсролын үйлчилгээнд хамрагдаж чадахгүй, эрсдэлд бүлгийн суралцагчийг сургууль, цэцэрлэгт сурах, хөгжихэд нь дэмжлэг үзүүлж боловсролд тэгш хамруулна.
- Цахим сургалтын санг хөгжүүлж, сургалтын хөтөлбөр, агуулга, хичээл боловсруулан, хэрэглэгдэхүүн бэлтгэн туршиж бүх насны иргэдэд суралцах боломжийг бүрдүүлнэ.
- Багш, мэргэжилтний мэргэжлийн ур чадвар, нэр хүнд, ёс зүй, шаардлага, хариуцлагыг өндөржүүлэн, мэдээлэл харилцааны технологи ашиглах ур чадварыг дээшлүүлж, ажлын байранд тасралтгүй хөгжүүлж, тэдний ажлыг үнэлэх, урамшуулах тогтолцоог нэвтрүүлнэ.
- Орон нутгийн онцлогоос хамаарч хос хэлний сургалтын бодлого, хөтөлбөр, олон хэлт боловсролын арга зүйг туршин хэрэгжүүлж, дэлгэрүүлнэ.
- Монгол хэлний сургалтыг сайжруулах цогц бодлого боловсруулан хэрэгжүүлнэ.
- Сургууль, цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлж, шинээр цэцэрлэг, сургууль барих ажлыг холбогдох төрийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.

### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

#### ***Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар***

Боловсрол шинжлэх ухааны газар нь Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг зарим хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Боловсролын ерөнхий газар, Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба нь байгууллагын санхүү, бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллага юм. Тус газрын 2024 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Боловсрол шинжлэх ухааны газар нь 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

#### **Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар**

Монгол Улсын Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын сайдын 2017 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн А/40 тоот тушаалаар баталсан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг" батлагдсан ба "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг салбарын байгууллагын хэмжээнд мөрдөж байна.

Тус газрын хэмжээнд мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Боловсрол шинжлэх ухааны газар 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2023 оны 229 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 376.0 сая төгрөгөөр буюу 62 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	
Авлага	100.0	100.00	00
Урьдчилгаа	-	-	
Бараа материал	63,144.10	344,614.1	-281,470.0
Үндсэн хөрөнгө	573,996.60	670,050.8	-96,054.2
<b>Нийт хөрөнгө</b>	<b>637,240.70</b>	<b>1,014,764.9</b>	<b>-377,524.2</b>
Өр төлбөр	0	0	
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	637,240.70	1,014,764.9	-377,524.2
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>637,240.70</b>	<b>1,014,764.9</b>	<b>-377,524.2</b>

Дээрх хүснэгтээс харахад бараа материал, үндсэн хөрөнгө дансанд өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан байна.

Бараа материалын үлдэгдэл оны эцэст 281.5 сая төгрөгөөр нэмэгдсэн нь бусад хангамжийн материалын үлдэгдэл нэмэгдсэнтэй холбоотой байна. Төсвийн хөрөнгөөр 14.3 сая төгрөгийн бараа материалыг худалдан авч, 3,187.4 сая төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй хүлээн авч, 19.2 сая төгрөгийн бараа материалыг үйл ажиллагаандаа зарцуулж, 2,900.6 сая төгрөгийн бараа материалыг шилжүүлж оны эцэст 344.7 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй гарсан байна.

Үндсэн хөрөнгийн үлдэгдэл оны эхнээс 95.1 сая төгрөгөөр нэмэгдсэн нь үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгөөс шалтгаалжээ. Төсвийн хөрөнгөөр 1.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн худалдан авч, бусад эх үүсвэрээр нийт 123.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авч, 1.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг шилжүүлсэн байна. Үндсэн хөрөнгөд 29.9 сая төгрөгийн элэгдэл байгуулсан байна.

Засгийн газрын хувь оролцоо данс тайлант үеийн үр дүнгээр 377.5 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 968.9 сая төгрөгөөр, нийт зарлагыг 968.9 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчаас төсвийг хянаж төсвийн төслийн саналаас 42 сая төгрөгөөр нэмэгдүүлэн, 1010.9 сая төгрөгөөр баталсан байна.

#### **Төсвийн гүйцэтгэл**

Тайлант оны батлагдсан төсөвт тодотгол хийгдсэн байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 11,123.5 сая төгрөгийг баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 11,123.5 сая төгрөгийн санхүүжилтийг авсан байна. Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 10,882.2 сая төгрөг буюу 97.8 хувьтай байна. Тайлант онд үндсэн санхүүжилтээс 241.3 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*  
/мянган төгрөгөөр/

код	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
71801-80802	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмж	2,147,191.60	1,962,156.70	185,034.80	91.38
71802-80802	Хөдөө орон нутгийн тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад олгох тэтгэмж	7,965,097.20	7,911,419.40	53,677.80	99.33
80801	Үндсэн үйл ажиллагааны зардал	1,010,942.0	1,008,679.8	2,262.1	99.78

80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж	315.4	00	315.4	00
	<b>Дүн</b>	<b>11,123,546.2</b>	<b>10,882,255.9</b>	<b>241,290.1</b>	<b>97.83</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Санхүүгийн тайлангийн аудитаар баримтлах ерөнхий чиглэлийн судалгааны дүн дараах байдалтай байна. Үүнд:

- Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-д заасны дагуу сан байгуулаагүй, ахмадын сангийн харилцах данс нээлгээгүй байна.
- Байгууллагын 2024 оны орон тооны судалгааг гаргуулж авч, хянаж үзэхэд батлагдсан орон тооны хязгаарыг баримталж ажилласан байна.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд 274.0 сая төгрөгийн нэмэлт санхүүжилтийг авч, 274.0 сая төгрөгийг зарцуулан байна.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Боловсрол шинжлэх ухааны газар нь 2024 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

### 3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Боловсрол шинжлэх ухааны газар нь худалдан авах үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж ажиллаагүй байна. Батлагдсан төсвийн хүрээнд 14.3 сая төгрөгийн бараа материал, 1.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Боловсрол шинжлэх ухааны газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хууль тогтоомжийн хэрэгжилт, бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Боловсрол шинжлэх ухааны газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор М.Айнур гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар тус тус хэрэгжүүлсэн.

Боловсрол шинжлэх ухааны газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 55 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Боловсрол шинжлэх ухааны газрын 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 4,870.4 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 48.7 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 4,825.2 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 34.1 сая төгрөг болж байна.

Боловсрол шинжлэх ухааны газрын нийт орлого, зардалд өмнөх оноос өөрчлөлт орсон байх тул материаллаг байдлыг гүйцэтгэлийн шатанд шинээр тогтоох нь зохимжтой гэж үзлээ.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор хуулийн хэрэгжилтийн хангаж ажилласан байна. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил илрээгүй.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд шилэн дансанд байршуулах мэдээллүүдийг бүрэн байршуулсан байна.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Баян-Өлгий аймгийн Боловсрол шинжлэх ухааны газрын 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй.

#### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй, албан шаардлага өгөгдөөгүй, зөвлөмж өгөгдөөгүй байна.

#### **4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байгаа болно.

### **5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

Аудитаар санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй. Аудитаар 7,850.0 мянган төгрөгийн зөрчил илэрч албан шаардлага өгөв.

#### **5.1 Төлбөрийн акт**

Төлбөрийн акт байхгүй.

#### **5.2 Албан шаардлага**

Аудитаар 7,850.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага өгөв.

1. Монгол Улсын Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн Б/39 дүгээр тушаалыг үндэслэн Боловсрол шинжлэх ухааны газрын дарга С.Хонаевд 3,866,000 төгрөгийн, нягтлан бодогч Н.Мухтард 2,942,000 төгрөгийн, Боловсрол шинжлэх ухааны газрын даргын 2024 оны 09 дугаар сарын 11-ны өдрийн Б/72-01 дугаар тушаалаар нярав Е.Маратад 1,042,000 төгрөгийн нийт 7,850,000 төгрөгийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар өөрчлөлтгүй дүгнэлт авсны балансын урамшуулал олгож, төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын хэмжээг хэтрүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5-д “Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 16.5.5-т “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Засгийн газрын 2019 оны “Журам батлах тухай” 05 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 2.2-т “Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн албан хаагчид олгох мөнгөн урамшууллыг холбогдох хууль, журам зөрчиж тогтоосон хэмжээнээс хэтрүүлэн олгохгүй байх

Аудитын шийдвэрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, албан шаардлагын 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн дотор Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### **5.3 Зөвлөмж**

Аудитын дүнгээр зөвлөмж өгөгдөөгүй байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Дүн</b>												

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал	1	7.8			1	7.8							
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>7.8</b>			<b>1</b>	<b>7.8</b>							

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
<b>Дүн</b>								